



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/152/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Б.Нарангэрэл Утас: 99009293 Цахим хаяг: Narangerelb@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа.....	Error! Bookmark not defined.
4.2 Төлбөрийн акт.....	Error! Bookmark not defined.
4.3 Албан шаардлага	16
4.3 Зөвлөмж	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

№ 176

БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЙГАЛЬ
ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Э.ГАНЗОРИГ
ТАНАА

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан, мөн АДБОУС 1240 (АОУС 240) дагуу сонгосон горим сорилоор доорх алдаа зөрчил илэрсэн нь "Хязгаарлалттай" дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлын зарцуулагдаагүй үлдэгдлийг мөнгөн гүйлгээ, үр дүнгийн тайланд зарцуулснаар тайлагнаж, нэмэлт санхүүжилтийн данс руу төвлөрүүлэн авлагаар тусгасан.

- Байгууллагын үндсэн дансаар хийгдсэн гүйлгээг бүртгээгүй орхигдуулсан, Тайлант хугацааны 182,031.3 мянган төгрөгийн 48 гүйлгээг тооцооны дансаар дамжуулаагүй, шууд зардалд бичсэн.

- Нягтлан бодогч байгууллагын жилийн эцсийн хөрөнгийн тооллогын тооцоо бодсон актыг үйлдээгүй, тооллогын дүнг баталгаажуулаагүй.

- Үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгүүдийг бараа материалд бүртгэсэн.

- Эмийн зардлаас худалдан авсан 2420.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг санхүүгийн орлого, зардлаар бүртгээгүй шууд зардлаар тайлагнасан.

D- alban bichig 2022 A4 TOOT

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн зарлагын хэмнэлтэд тооцно", 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5 "бүх орлого", 14.4.6 "бүх зарлага", 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар" -ын 4.30 "Үндсэн хөрөнгийн зүйлийг дараах тохиолдолд хөрөнгө хэмээн хүлээн зөвшөөрнө" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "Тохиолдсон байх", "Үнэлгээ ба хуваарилалт", "Ангилал", "Толилуулга", "Оршин байх", "Эрх ба үүрэг", "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргаж хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	205,856,369.00	195,744,645.29
33	АВЛАГА	0	77,366,418.79
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0	47,174,968.79
33500	Бусад авлага	0	30,191,450.00
33510	Байгууллагаас авах авлага	0	30,191,450.00
35	БАРАА МАТЕРИАЛ	82,461,956.50	108,378,226.50
35100	Түүхий эд материал	11,805,000.00	28,580,000.00
35110	Тусгай зориулалттай материал	11,805,000.00	28,580,000.00
35400	Хангамжийн материал	70,656,956.50	79,798,226.50
35410	Бичиг хэргийн материал	200,000.00	556,900.00
35420	Аж ахуйн материал	21,403,960.00	15,512,370.00
35440	Түлш, шатах тослох материал	0	1,675,960.00
35450	Барилгын засварын материал	320,000.00	320,000.00
35470	Бусад хангамжийн материал	48,732,996.50	61,732,996.50
36	НӨӨЦИЙН БАРАА	123,394,412.50	10,000,000.00
36100	Барааны нөөц	123,394,412.50	10,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	445,365,898.63	444,324,275.39
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	445,365,898.63	444,324,275.39
39200	Биет хөрөнгө	400,815,898.63	392,737,608.69
39201	Барилга, байгууламж, орон сууц	297,620,468.47	268,890,468.47
39202	Хуримтлагдсан элэгдэл	-9,191,723.04	-17,588,199.12
39203	Авто-тээврийн хэрэгсэл	108,110,000.00	133,110,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-44,287,777.94	-69,026,666.70
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	100,583,830.00	124,075,211.45
39206	Хуримтлагдсан элэгдэл	-68,110,868.89	-80,986,825.34
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,511,080.00	40,865,230.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,542,107.97	-11,057,941.37
39214	Бусад үндсэн хөрөнгө	0	6,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	0	-1,666,666.70
39217	Ном	122,998.00	122,998.00
39300	Биет бус хөрөнгө	44,550,000.00	51,586,666.70
39301	Програм хангамж	770,000.00	7,990,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-770,000.00	-953,333.30
39303	Бусад биет бус хөрөнгө	44,550,000.00	44,550,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	651,222,267.63	640,068,920.68
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	129,606.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	129,606.00
41300	Өглөг	0	129,606.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0	31,550.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0	98,056.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	651,222,267.63	639,939,314.68
51	Засгийн газрын хувь оролцоо	651,222,267.63	639,939,314.68
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	252,228,714.62	252,228,714.62
51200	Хуримтлагдсан үр дүн	206,274,627.26	194,991,674.31
51210	Өмнөх үеийн үр дүн	94,506,378.77	206,274,627.26
51220	Тайлант үеийн үр дүн	111,768,248.49	-11,282,952.95
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	192,718,925.75	192,718,925.75
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	651,222,267.63	640,068,920.68

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	961,720,862.00	892,705,341.45
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,255,562.00	98,156,491.45
120	Нийтлэг татварын бус орлого	22,255,562.00	98,156,491.45
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	22,255,562.00	950,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	910,000.00	950,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	21,345,562.00	0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0	81,065,531.45
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0	16,140,960.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	939,465,300.00	794,548,850.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,275,000.00	54,841,450.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,375,000.00	10,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,900,000.00	44,841,450.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	920,190,300.00	739,707,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	920,190,300.00	739,707,400.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	849,952,613.51	876,575,086.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	849,952,613.51	876,575,086.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	810,113,584.51	863,507,703.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	409,852,976.00	430,765,930.00
210101	Үндсэн цалин	318,944,716.00	326,353,122.00
210102	Нэмэгдэл	53,962,146.00	71,471,466.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,385,000.00	32,941,342.00
210105	Гэрээт ажлын хөлс	3,561,114.00	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,639,839.00	54,726,616.21
210201	Тэтгэврийн даатгал	50,639,839.00	40,652,895.25
210202	Тэтгэмжийн даатгал	0	3,708,423.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	0	2,864,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0	751,230.43
210205	Эрүүл мэндийн даатгал	0	6,749,366.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,916,096.00	17,140,484.40
210301	Гэрэл, цахилгаан	1,871,573.00	1,483,702.40
210302	Түлш, халаалт	14,239,731.00	14,049,870.00
210303	Цэвэр, бохир ус	804,792.00	1,606,912.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,798,072.00	31,971,005.83
210401	Бичиг хэрэг	4,551,300.00	5,036,600.00
210402	Тээвэр, шатахуун	11,068,962.00	11,091,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,295,000.00	2,332,415.83
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	330,000.00	622,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,693,910.00	4,400,490.00
210408	Бараа материал акталсны зардал	18,858,900.00	8,488,000.00
2105	Нормативт зардал	4,925,000.00	919,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0	919,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,925,000.00	0

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,201,900.00	8,755,790.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	76,500.00	0
210604	Урсгал засвар	5,125,400.00	8,755,790.00
2107	Томилолт, зочны зардал	4,585,400.00	6,604,000.00
210702	Дотоод албан томилолт	4,585,400.00	6,604,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	197,601,051.00	177,246,870.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	195,002,351.00	176,206,762.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,900,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	298,500.00	289,908.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	72,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	178,200.00	178,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	81,593,250.51	135,377,306.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,166,100.00	75,108,550.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	742,100.00	5,574,810.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	54,685,050.51	54,693,946.43
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,839,029.00	13,067,382.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,336,000.00	8,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,955,800.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,380,200.00	8,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,503,029.00	5,067,382.77
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,503,029.00	5,067,382.77
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	111,768,248.49	16,130,255.31
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	27,413,208.26
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0	27,413,208.26
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	111,768,248.49	-11,282,952.95

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	940,375,300.00	795,498,850.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	910,000.00	950,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	910,000.00	950,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	910,000.00	950,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	910,000.00	950,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	939,465,300.00	794,548,850.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,275,000.00	54,841,450.00

**Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,375,000.00	10,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,900,000.00	44,841,450.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	920,190,300.00	739,707,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	920,190,300.00	739,707,400.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	926,284,370.00	795,498,850.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	926,284,370.00	795,498,850.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	884,445,341.00	754,240,017.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	409,327,395.00	431,836,710.00
210101	Үндсэн цалин	318,944,716.00	318,987,600.00
210102	Нэмэгдэл	53,962,145.00	79,454,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,385,000.00	33,395,110.00
210105	Гэрээт ажлын хөлс	3,035,534.00	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,141,361.00	56,012,555.00
210201	Тэтгэврийн даатгал	35,695,085.00	39,334,347.25
210202	Тэтгэмжийн даатгал	3,343,690.00	4,213,892.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,414,312.00	3,134,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	541,487.00	824,230.43
210205	Эрүүл мэндийн даатгал	8,146,787.00	8,505,384.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,916,096.00	17,042,428.40
210301	Гэрэл, цахилгаан	1,871,573.00	1,483,702.40
210302	Түлш, халаалт	14,239,731.00	14,049,870.00
210303	Цэвэр, бохир ус	804,792.00	1,508,856.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,493,700.00	25,254,115.83
210401	Бичиг хэрэг	3,256,800.00	5,256,800.00
210402	Тээвэр, шатахуун	10,423,400.00	12,423,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,295,000.00	2,332,415.83
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	622,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,158,500.00	4,619,500.00
2105	Нормативт зардал	9,149,700.00	4,000,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	919,700.00	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,230,000.00	4,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,339,070.00	11,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	909,070.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	5,430,000.00	10,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,585,400.00	6,604,000.00
210702	Дотоод албан томилолт	4,585,400.00	6,604,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	285,357,196.00	33,612,708.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	282,758,496.00	32,572,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,900,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	298,500.00	289,908.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	72,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	178,200.00	178,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	84,135,423.00	168,877,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	83,393,323.00	163,135,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	742,100.00	5,742,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,839,029.00	41,258,832.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,336,000.00	6,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,955,800.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,380,200.00	6,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,503,029.00	35,258,832.77
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,503,029.00	5,067,382.77
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0	30,191,450.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	14,090,930.00	0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	14,090,930.00	0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,090,930.00	0
2200	Дотоод эх үүсвэрээр	14,090,930.00	0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,090,930.00	0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-14,090,930.00	0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	252,228,714.62	192,718,925.75	94,506,378.77	539,454,019.14
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	252,228,714.62	192,718,925.75	94,506,378.77	539,454,019.14
9	Тайлант үеийн үр дүн	0	0	111,768,248.49	111,768,248.49
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	252,228,714.62	192,718,925.75	206,274,627.26	651,222,267.63
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	252,228,714.62	192,718,925.75	206,274,627.26	651,222,267.63
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	252,228,714.62	192,718,925.75	206,274,627.26	651,222,267.63
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-11,282,952.95	-11,282,952.95
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	252,228,714.62	192,718,925.75	194,991,674.31	639,939,314.68

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Батлагдсан Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	740,707,400.00	735,590,017.23	5,117,382.77	99.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	740,707,400.00	735,590,017.23	5,117,382.77	99.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	734,707,400.00	729,590,017.23	5,117,382.77	99.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	431,837,600.00	431,836,710.00	890.00	100.0
210101	Үндсэн цалин	318,987,600.00	318,987,600.00	0.00	100.0
210102	Нэмэгдэл	79,454,000.00	79,454,000.00	0.00	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,396,000.00	33,395,110.00	890.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,010,400.00	56,012,555.00	1,997,845.00	96.6
210201	Тэтгэврийн даатгал	41,536,800.00	39,334,347.25	2,202,452.75	94.7
210202	Тэтгэмжийн даатгал	4,118,400.00	4,213,892.56	-95,492.56	102.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,134,700.00	3,134,700.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	823,700.00	824,230.43	-530.43	100.1
210205	Эрүүл мэндийн даатгал	8,396,800.00	8,505,384.76	-108,584.76	101.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,517,900.00	17,042,428.40	475,471.60	97.3
210301	Гэрэл, цахилгаан	2,342,000.00	1,483,702.40	858,297.60	63.4
210302	Түлш, халаалт	14,274,100.00	14,049,870.00	224,230.00	98.4
210303	Цэвэр, бохир ус	901,800.00	1,508,856.00	-607,056.00	167.3
2104	Хангамж, бараа материалын зардал	26,615,700.00	25,254,115.83	1,361,584.17	94.9
210401	Бичиг хэрэг	5,256,800.00	5,256,800.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	12,423,400.00	12,423,400.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,295,000.00	2,332,415.83	962,584.17	70.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	622,000.00	578,000.00	51.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,440,500.00	4,619,500.00	-179,000.00	104.0

Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2105	Нормативт зардал	4,000,000.00	4,000,000.00	0.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,000,000.00	4,000,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,000,000.00	11,000,000.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	10,000,000.00	10,000,000.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	6,723,600.00	6,604,000.00	119,600.00	98.2
210702	Дотоод албан томилолт	6,723,600.00	6,604,000.00	119,600.00	98.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,124,700.00	8,962,708.00	1,161,992.00	88.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,065,000.00	7,922,600.00	1,142,400.00	87.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	298,500.00	289,908.00	8,592.00	97.1
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	22,000.00	11,000.00	66.7
210807	Газрын төлбөр	178,200.00	178,200.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	168,877,500.00	168,877,500.00	0.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	163,135,000.00	163,135,000.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,742,500.00	5,742,500.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,000,000.00	6,000,000.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,000,000.00	6,000,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,000,000.00	6,000,000.00	0.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	740,707,400.00	735,590,017.23	5,117,382.77	99.3
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	739,707,400.00	734,640,017.23	5,067,382.77	99.3
320001	Орон нутгийн төсвөөс	739,707,400.00	734,640,017.23	5,067,382.77	99.3
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	950,000.00	50,000.00	95.0
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	950,000.00	50,000.00	95.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	95	95		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
610001	Төсвийн байгууллага	1	1		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	47	47		
620001	Удирдах ажилтан	1	1		
620002	Гүйцэтгэх ажилтан	43	43		
620003	Үйлчлэх ажилтан	3	3		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	47	47		
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	37	37		
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10	10		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	19,275,000.0	54,841,450.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	19,275,000.0	54,841,450.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	19,275,000.0	24,650,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,275,000.0	24,650,000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,275,000.0	24,650,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	30,191,450.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	30,191,450.0
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		30,191,450.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	19,275,000.0	54,841,450.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,275,000.0	54,841,450.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.0	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,375,000.0	10,000,000.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,900,000.0	44,841,450.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн ба төсвийн зарцуулалтын эрхийн хүсэлтэд нэгдүгээр гарын үсгийг дарга Э.Ганзориг, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Д.Мөнхнасан нар зурсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Байгаль орчин, аялал жуулчлалын хууль тогтоомжийг харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх, байгаль хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчин, аялал жуулчлалын мэдээллийн сан бүрдүүлэх, аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх, сургалт сурталчилгааны ажлыг гүйцэтгэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 849,952.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 8,499.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,949.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд, 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 9,214.1 мянган төгрөг, гүйцэтгэлийн материаллаг байдал 6,449.9 мянган төгрөг байгаа тул, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 55,988.3 мянган төгрөгөөр буюу 9.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	205,856.4	195,744.6	(10,111.7)
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	77,366.4	77,366.4
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	205,856.4	118,378.2	(87,478.1)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	445,365.9	444,324.3	(1,041.6)
Үндсэн хөрөнгө	573,268.4	625,603.9	52,335.5
Хуримтлагдсан элэгдэл	(127,902.5)	(181,279.6)	(53,377.2)
Нийт хөрөнгө	651,222.3	640,068.9	(11,153.3)
Өр төлбөр	-	129.6	129.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	651,222.3	639,939.3	(11,283.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	651,222.3	640,068.9	(11,153.3)

Авлaгын дансны үлдэгдэл 77366.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулагдаагүй үлдэгдэл болох 30,191.5 мянган төгрөгийг тайлант оны авлагаар бүртгэсэн, “Би эйч энд ди” ХХК-руу материалын үнэ гэрээний дагуу 44,835.0 мянган төгрөгийг шилжүүлсэн ч, хөрөнгийг хүлээн аваагүй тул авлагаар тусгасан, мөн нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлт болох 1285.9 мянга, ХХОАТ-ын илүү төлөлт 1054.0 мянган төгрөгийг авлагаар тусгасантай тус тус холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 118,378.2 мянган төгрөг болж 87,478.1 мянган төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын материал 16,775.0, хангамжийн материал 9,141.3 мянган төгрөгөөр буурсан бөгөөд, барааны нөөц данс 113,394.4 мянган төгрөгийн “Оготонотой булаг”-ийн тохижилтын ажлыг Хот тохижилт ОНӨААТҮГ-т шилжүүлсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 625,603.9 мянган төгрөг болж өмнөх оноос 52,335.5 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021.02.01-ний өдрийн №19 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын дэргэдэх Гадаад харилцаа, аялал жуулчлалын албыг татан буулгаж, 32,395.5 мянган төгрөгийн хөрөнгийг БОАЖГ-т шилжүүлсэн, аймгийн ОНӨГ-ын 2021.06.30-ны өдрийн А/144 дүгээр албан бичгээр 25,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий тээврийн хэрэгсэл, Баянхонгор аймгийн Засаг даргын 2021.05.11 -ний өдрийн А/296 дугаар захирамжаар 10,800.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, программ хангамж, БОАЖГ-ын 2021.10.05-ны өдрийн 306 дугаар албан бичгээр ГХУСАЗЗ-д хүсэлт гаргасны дагуу 1670.0 мянган төгрөгийн өртөг бүхий 1 зөөврийн компьютер, мөн Экологи сургалт судалгааны төвтэй хамтран ажиллах гэрээний дагуу 11,200.0 мянган төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021.10.15-ны өдрийн 116 дугаар тогтоолоор Эхийн голд шатсан 28,730.0 мянган төгрөгийн барилгыг акталж, данснаас хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 595,104.3 мянган төгрөг болж 56,118.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 56,118.0 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд төсвийн нийт эх үүсвэрийг 1,221,573.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 489,918.0 мянган төгрөгөөр бууруулж 731,655.1 мянган төгрөгөөр анх батлагдаж 1 удаа тодотгож 740,707.4 мянган төгрөгөөр батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг 7408707.4 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 739,707.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, өөрийн орлогоор 950.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 735,590.0 мянган төгрөгийг зарцуулж 5,067.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 735,590.0 мянган төгрөг буюу 99.3 хувьтай байгаа нь ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг зардлыг 1,997.8 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 475.5 мянга, хангамж бараа материалын зардлыг 1,361.6 мянга, томилолтын зардлыг 119.6 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 1161.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас 30191.5 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данс руу төвлөрүүлж, мөнгөн гүйлгээний тайлан, үр дүнгийн тайланд зардлаас тайлагнаж, уг санхүүжилтийг тайлант хугацааны авлагаар тусгасан байна.

Баянхонгор аймгийн цөлжилт газрын доройтолд өртсөн газарт хамгаалалтын зурвас байгуулах зорилгоор "Ойн зурвасын усалгааны систем, хамгаалалтын хашааны материал" нийлүүлэхээр нийт 171,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй тендер зарлаж, "Би эйч энд ди" ХХК нь 163,965.5 мянган төгрөгийн үнийн санал ирүүлж, хамгийн сайн үнэлэгдсэн тендерээр шалгарч гэрээ байгуулсан байна. Гэрээний 100,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, 64,050.0 мянган төгрөгийн санхүүжилтийг аймгийн байгаль орчныг нөхөн сэргээх зардлаас гаргахаар гэрээ хийсэн байна. Аймгийн БОАЖГ нь тус байгууллагатай байгуулсан гэрээний үнийн 70 хувь болох 44,835.0 мянган төгрөгийг 2021.06.24-ны өдөр шилжүүлсэн. Үлдэгдэл 19215.0 мянган төгрөгийг бараа нийлүүлэлтийг бүрэн хийж дууссаны дараа өгөхөөр гэрээнд заажээ. Ковид-19 цар тахлын улмаар хил хаасны улмаас уг барааг гэрээнд заасан хугацаандаа нийлүүлээгүй байхад авлагаар тусгаагүй байгаа бөгөөд уг бараа материалыг 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр хүлээн авсан акт үйлдсэн байна.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд нийт 76 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 90.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 921,410.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 71,457.5 мянган төгрөгөөр буюу 8.4 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд, цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, дотоод албан томилолтын зардал, бараа үйлчилгээний бусад зардал, эд хогшил худалдан авах зардал өмнөх оноос нэмэгдсэн байгаа бол, хангамж бараа материалын зардал, нормативд зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 1,199,769.7 мянган төгрөгийн 49 мэдээллээс хуулийн 6.1.2-д заасан төсвийн гүйцэтгэлийн мэдээг 3 дугаар улирал, , 6.4.5-д заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 99,110.1 мянган төгрөгийн орлогын 2 гүйлгээг хугацаа хоцроосон, хуулийн 6.1.2-д заасан төсвийн гүйцэтгэлийн 4 дүгээр улирал, 6.4.3-д заасан тендэрт шалгарсан оролцогчийн товч мэдээлэл, 6.4.5-д заасан орлогын 181782.2 мянган төгрөгийн 2 гүйлгээ, 30191.5 мянган төгрөгийн 1 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.

.3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна.Үүнд:

- 2021 оны төсвийг 731,665.1 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 9,042.3 мянган төгрөг нэмж 739,707.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,000.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр баталсан ба гүйцэтгэлээр 735,590.0 мянган төгрөг зарцуулж, орон нутгийн төсөвт 5,067.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байгаа нь нийт зардлын 0.7 хувийг хэмнэсэн гэж үзэхээр байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1¹ гэсэн заалттай нийцэхгүй байна.

- Бичиг хэргийн зардлыг 5,286.8 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 5,286.8 мянган төгрөг зарцуулсан нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.9² дахь заалттай нийцэхгүй байна.

-Албан томилолтын зардлыг 6,723.6 мянган төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 6,604.0 мянган төгрөг зарцуулсан нь батлагдсан төсөвт 1.8 хувийн хэмнэлт гаргасан.

- Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 19,470.0 мянган төгрөгөөр, тодотголоор 17,517.9 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 17,042.4

1. Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах

2. бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах.

мянган төгрөг зарцуулж, анх баталсан дүнгээс 2,427.6 мянган төгрөг буюу 14.2 хувь хэмнэсэн.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 12,922.5 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, 6789.1 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 6,133.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд байгаль хамгаалах нөхөн сэргээх зардалд 163,135.0 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр 132,943.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 30191.5 мянган төгрөгийг зарцуулаагүй байхад санхүүгийн тайланд зарцуулснаар тайлагнасан бөгөөд хэрэгжилтийг үзээгүй болно.

Тус байгууллага нь Би эйч энд ди ХХК тай 64,050.0 мянган төгрөгийн "Ойн зурвасын усалгааны систем, хамгаалалтын хашааны материал" нийлүүлэхээр гэрээ байгуулсан. Тус байгууллагатай байгуулсан гэрээний үнийн 70 хувь болох 44,835.0 мянган төгрөгийг 2021.06.24-ны өдөр шилжүүлсэн. Үлдэгдэл 19215.0 мянган төгрөгийг бараа нийлүүлэлтийг бүрэн хийж дууссаны дараа өгөхөөр гэрээнд заажээ. Ковид-19 цар тахлын улмаар хил хаасны улмаас уг барааг гэрээнд заасан хугацаандаа нийлүүлээгүй байна. Уг асуудлыг дараагийн аудитаар авч үзэх.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 301,352.2 мянган төгрөгийн 11 алдаа зөрчил илэрснээс 44835.0 төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 30191.5 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 31,217.5 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 195,108.2 мянган төгрөгийн 5 зөвлөмжийг хүргүүллээ.

4.1 Залруулга

1. Тус байгууллага нь Би эйч энд ди ХХК тай 64,050.0 мянган төгрөгийн "Ойн зурвасын усалгааны систем, хамгаалалтын хашааны материал" нийлүүлэхээр гэрээ байгуулсан. Тус байгууллагатай байгуулсан гэрээний үнийн 70 хувь болох 44,835.0 мянган төгрөгийг 2021.06.24-ны өдөр шилжүүлсэн. Үлдэгдэл 19215.0 мянган төгрөгийг бараа нийлүүлэлтийг бүрэн хийж дууссаны дараа өгөхөөр гэрээнд заажээ. Ковид-19 цар тахлын улмаар хил хаасны улмаас уг барааг гэрээнд заасан хугацаандаа нийлүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд авлагаар тусгаж, залруулах.

4.2 Төлбөрийн акт

1. Тус байгууллага нь байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас 30191.5 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данс руу төвлөрүүлж, мөнгөн гүйлгээний тайлан, үр дүнгийн тайланд зардлаас тайлагнаж, уг санхүүжилтийг тайлант хугацааны авлагаар тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-дах "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 45 дугаар зүйлийн 45.1 дэх "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн зарлагын хэмнэлтэд тооцно" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт", "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгаль хамгаалах зардлыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, тайлант хугацааны зардлаар тайлагнасан тул орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

1. 2021 онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1000.0 мянган төгрөгийн үнэ бүхий хяналтын камер, 10,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг бусад хангамжийн материалын дансанд бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар" -ын 4.30 "Үндсэн хөрөнгийн зүйлийг дараах тохиолдолд хөрөнгө хэмээн хүлээн зөвшөөрнө" гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх 11,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий хөрөнгүүдийг зөв анги дансанд бүртгэж, зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

2. Байгууллагын жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг тулгахад хөрөнгийг байгууллагын даргын тушаалын дагуу тооллого явуулсан ч нягтлан бодогч тооцоо бодсон акт үйлдээгүй, тооллогын дүнг дарга баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6."эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодогч тооцоо бодсон акт үйлдэж, эрх бүхий албан тушаалтнаар тооллогын дүнг баталгаажуулж, зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуулийн 6.1.2-д заасан төсвийн гүйцэтгэлийн мэдээг 3 дугаар улирал, 6.4.5-д заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 99,110.1 мянган төгрөгийн орлогын 2 гүйлгээг хугацаа хоцроосон, хуулийн 6.1.2-д заасан төсвийн гүйцэтгэлийн 4 дүгээр улирал, 6.4.3-д заасан тендерт шалгарсан оролцогчийн товч мэдээлэл, 6.4.5-д заасан орлогын 181782.2 мянган төгрөгийн 2 гүйлгээ, 30191.5 мянган төгрөгийн 1 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.1.2," хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор", 6.4.3 "тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан", 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6.1.2-д заасан төсвийн гүйцэтгэлийн 4 дүгээр улирал, 6.4.3-д заасан тендерт шалгарсан оролцогчийн товч мэдээлэл, 6.4.5-д заасан орлогын 181782.2 мянган төгрөгийн 2 гүйлгээ, 30191.5 мянган төгрөгийн 1 гүйлгээг нөхөн мэдээлүүлж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

4. Санхүүгийн тайланд тусгагдсан бараа материалын тайлангийн хөдлөл өөрчлөлт нь нярвын аж ахуйн тайлангаас орлогын 12605.3 мянга, зарлагын 7612.2 мянга, эцсийн үлдэгдэл 4993.1 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй илэрхийлэгдсэн.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодогч орхигдуулсан гүйлгээг бүртгэж, зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

1. Байгууллагын даргын 2021.10.29-ны өдрийн А/70 дугаар тушаалаар Төрийн албанаас зохион байгуулж буй "Ёс зүй, хандлага зөвтэй төрийн алба" сарын аяны хүрээнд байгууллагын 3 үеийн уулзалтад зориулж төсвөөс 1200.0 мянган төгрөгийг нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас, байгууллагын ажилтан албан хаагчдад бүжгийн хичээл заалгахаар хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 252.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж, төсвийг зориулалтын дагуу, үр ашигтай хэмнэлттэй зарцуулж байх зөвлөмжийг өгөв.

2. Байгууллагын даргын 2021.12.13-ны өдрийн А/83 дугаар тушаалаар МУ-ын ерөнхийлөгчийн санаачилгаар "Нэг тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд ажилтан албан хаагчдыг чадавхжуулах сургалт хэлэлцүүлгийг сумдын байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагчдыг хамруулан аймгийн төвд 2 өдөр, Шаргалжуут рашаан сувилалд 2 өдөр зохион байгуулж, нийт 4892.9 мянган төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн зардлаас зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.4 "салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний талаар Засгийн газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

3. 2021 оны төсвийг 731,665.1 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 9,042.3 мянган төгрөг нэмж 739,707.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,000.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр баталсан ба гүйцэтгэлээр 735,590.0 мянган төгрөг зарцуулж, орон нутгийн төсөвт 5,067.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байгаа нь нийт зардлын 0.7 хувийг хэмнэсэн, мөн бичиг хэргийн зардлыг 5,286.8 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 5,286.8 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 " Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах", 1.9 "бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний талаар Засгийн газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

4. Нэмэлт санхүүжилтийн данснаас үндсэн данс руу зөвшөөрөлгүй 3000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн бөгөөд үндсэн данснаас хуванцар хогийн сав хийлгэсэн

компани руу гэрээний үлдэгдэл төлбөр болох 3000.0 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн ч санхүүгийн тайланд бүртгээгүй байна. Мөн үндсэн дансруу орсон 3000.0 мянган төгрөгийн орлогыг бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5 "бүх орлого", 14.4.6 "Бүх зарлага" 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, зааврын дагуу бүртгэлийг хөтөлж байх зөвлөмж өгөв.

5. Тайлант хугацааны гэрэл цахилгааны зардлаас 607.1 мянган төгрөгийг цэвэр бохир усны төлбөрт төлж шийдвэргүйгээр гүйлгэн зарцуулсан, мөн 182,031.3 мянган төгрөгийн 48 гүйлгээг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бичсэн, 3124.9 мянган төгрөгийн и баримтгүй 2 гүйлгээ хийсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, зааврын дагуу бүртгэлийг хөтөлж байх зөвлөмж өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар өгсөн зөвлөмжийн бүрэн хэрэгжүүлж биелэлтийг нотлох баримтын хамт 2022 оны 05 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар	11	301,352.2	1	44835.0	1	30191.5	4	31,217.5	5	195,108.2

_____оОо_____